

БАТЛАВ
"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



.....Р.БАТСҮХ

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2020 оны 04 дугаар
сарын 09 -ны өдөр

Дугаар АТТ-20/97-95/26

Улаанбаатар
хот

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү эрчим хүчний барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг (цаашид "Гэрээ" гэх)

Нэг талаас: "Монголын төмөр зам" ТӨХК (цаашид "Захиалагч" гэх),

Нөгөө талаас: "Багануур Энерги" ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэх), (цаашид хамтад нь "Талууд" гэх) нар Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийг удирдлага болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

1.2. Гэрээний зорилго нь Гүйцэтгэгч нь стандарт, норм, дүрэм, техникийн нөхцөл, тойм зураг, төсвийн дагуу гэрээнд заасан ажлыг тохиролцсон хугацаанд хийж гүйцэтгэх, Захиалагч нь үнэ, ажлын хөлсийг гэрээнд заасны дагуу төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах, Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага болон тэдгээртэй холбогдсон бусад харилцааг тодорхойлох, зохицуулахад оршино.

1.3. Энэхүү гэрээ нь энэ гэрээ болон түүний хавсралтуудаас бүрдэнэ. Гэрээ, түүний хавсралтад оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

2. Гэрээний зүйл

2.1. Энэхүү гэрээний зүйл нь Захиалагчийн өгсөн ажлын даалгавар, зургийн дагуу Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн далангийн Дорноговь аймгийн Хөвсгөл болон Мандах сумын 15-22кВ цахилгаан дамжуулах агаарын шугамтай огтлолцож буй 3 цэгт /№4,5,6/ агаарын шугамыг кабель шугамаар солих эрчим хүчний барилга угсралтын ажил байна.

2.2. Гүйцэтгэгч нь ажлыг гэрээний хавсаргалт 1-т заасан Цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл, хавсаргалт 2-т заасан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замтай огтлолцож байгаа цэгүүдэд цахилгаан дамжуулах кабель шугамаар солих ажлын зургийн дагуу хавсаргалт 3-т заасан ажил гүйцэтгэх календарьчилсан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.

2.3. Гэрээнд заасан Ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэх Гүйцэтгэгч нь эрчим хүчний ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

2.4. Ажил гүйцэтгэхдээ үр ашигтай техник, технологийг сонгон ажиллах ба ажил гүйцэтгэх хугацааг богиносгож, чанарыг техникийн тодорхойлолт, норм, дүрэм, зааварт заасан нормативт хэмжээнээс бууруулалгүй, төлөвлөсөн санхүүжилтэд багтаах, нөөц бололцоог ашиглах, хэмнэлтийн зарчмыг баримтлан ажиллана.

2.5. Дараах бичиг баримтыг гэрээнд хавсаргах бөгөөд эдгээр нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно. Үүнд:

2.5.1. Цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл; /Хавсаргалт 1/

2.5.2. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замтай огтлолцож байгаа цэгүүдэд цахилгаан дамжуулах кабель шугамаар солих ажлын зураг; /Хавсаргалт 2/

2.5.3. Ажил гүйцэтгэх календарьчилсан төлөвлөгөө /Хавсралт 3/

2.6. Энэхүү гэрээгээр зохицуулаагүй, тусгагдаагүй бусад харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актаар зохицуулж шийдвэрлэнэ.

3. Баталгаа

3.1. Захиалагч нь гэрээний дагуу ажил гүйцэтгүүлэх захиалга өгөх, гэрээнээс үүсэх эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй, энэхүү гэрээг байгуулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай эрхийг эрх бүхий байгууллагаас авсан гэдгийг үүгээр баталж байна.

3.2. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу ажил гүйцэтгэх, гэрээнээс үүсэх эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй, энэхүү гэрээг байгуулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, эрхийг эрх бүхий байгууллагаас авсан, тэдгээр нь гэрээний үүргийг зохих ёсоор бүрэн гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр, гэрээнд заагдсан ажлыг гүйцэтгэх боловсон хүчний болон санхүүгийн бүрэн чадамжтай гэдгийг үүгээр баталж байна.

3.3. Гүйцэтгэгч нь ажлыг хууль тогтоомж болон энэ гэрээнд заасан шаардлагад нийцүүлэн, эрхийн болон биет байдлын доголдолгүй, холбогдох бичиг баримт нь үнэн зөв, бүрэн гүйцэд хүлээлгэж өгнө гэдгийг үүгээр баталж байна.

3.4. Талууд энэхүү Гэрээг байгуулахтай холбогдуулан мэдсэн нөгөө талын үйл ажиллагаатай холбоотой нууц мэдээллийг тухайн талын зөвшөөрөлгүйгээр хууль болон энэ гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй, энэхүү гэрээнээс үүссэн харилцаанаас өөр бусад зорилгоор ашиглахгүй байхыг үүгээр баталж байна.

4. Хууль тогтоомж, гэрээг тайлбарлах

4.1. Талууд Гэрээг Монгол Улсын хууль тогтоомжид үндэслэн, эрх бүхий байгууллагаас баталсан аливаа дүрэм, журам, заавар, стандарт, шаардлагад нийцүүлэн талуудын хоорондын эрх тэгш, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан байгуулав.

4.2. Гэрээний зүйл заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд хэрэв энэ гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын хуульд заасныг баримтална.

5. Гэрээгбайгуулсанд тооцох

5.1. Гэрээнд талуудын төлөөлөх эрхтэй этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

5.2. Гэрээг монгол хэлээр гурван хувь үйлдэх ба Гүйцэтгэгч нэг хувийг, Захиалагч хоёр хувийг тус тус хадгалах бөгөөд хувиуд хууль зүйн адил хүчинтэй байна.

5.3. Талууд гэрээг бүртгүүлэх, батлуулах шаардлагатай тохиолдолд түүнтэй холбоотойгоор холбогдох бүхий л баримт бичиг, мэдээллийг гарган өгч хамтран ажиллана.

6. Ажил гүйцэтгэх хугацаа

6.1. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба Гүйцэтгэгч уг хугацаанд багтааж гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж дууссан байна.

6.2. Давагдашгүй хүчин зүйлээс бусад тухайлбал, ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, ажил гүйцэтгэхэд шаардагдах техник тоног төхөөрөмжийг тээвэрлэхэд гарсан аливаа саатал, эрсдэл, санхүүгийн хүндрэл, энэ гэрээнд заасны дагуу ажлын гүйцэтгэлийн доголдлыг арилгасан зэрэг нь ажил гүйцэтгэх хугацааг зөрчих буюу

хойшлуулах үндэслэл болохгүй.

6.3. Ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл хугацаа хожимдуулж гүйцэтгэсэн нь ажил гүйцэтгэгчид захиалагчийн зүгээс энэ гэрээнд заасан алданги болон торгууль ногдуулах үндэслэл болно.

7. Ажлын гүйцэтгэлд хяналт тавих

7.1. Ажлын гүйцэтгэлд Захиалагч хяналт тавина.

7.2. Гүйцэтгэгч талаас бэлтгэн өгсөн ажил гүйцэтгэх календарьчилсан төлөвлөгөө дагуу Захиалагч нь ажлын гүйцэтгэлийг дараах байдлаар шалгана. Үүнд:

7.2.1. Гэрээ байгуулагдсанаас хойш 1 дэх долоо хоногт;

7.2.2. Гэрээ байгуулагдсанаас хойш 2 дахь долоо хоногт;

7.2.3. Гэрээ байгуулагдсанаас хойш 3 дахь долоо хоногт;

7.3. Ажлын гүйцэтгэлд хяналт тавих зорилгоор Захиалагч болон түүний ажилтан нь дараах эрх эдэлнэ:

7.3.1. Ажлын явцыг газар дээр нь үзэж шалгах, дүрс бичлэг болон фото зургаар баримтжуулах;

7.3.2. Хөндлөнгийн шинжээч урьж ажиллуулах, дүгнэлт гаргуулах;

7.3.3. Шаардлагатай тайлбар, мэдээлэл, баримт бичгийг ажил гүйцэтгэгчээс гаргуулан авах.

7.4. Захиалагч болон Гүйцэтгэгч нь гүйцэтгэл, чанарыг дараах хугацаанд хамтран шалгаж баталгаажуулна:

7.4.1. Цахилгаан дамжуулах шугамын ажлыг барьж дуусган хүлээлцэхэд,

7.5. Ажлын гүйцэтгэлийг хамтран шалгаж баталгаажуулахдаа талууд хамтарсан тэмдэглэл үйлдэн, ийнхүү шалгасан эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зуран баталгаажуулна.

7.6. Талууд ажлын гүйцэтгэлийн хувь хэмжээ, явц, чанарын талаар харилцан тохиролцож чадаагүй, эсхүл аль нэг талын гаргасан тайлбар, үндэслэл, дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй, тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан бол захиалагчийн сонгосон шинжээчээр дүгнэлт гаргуулж, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулна. Ийнхүү дүгнэлт гаргуулахад гарсан нэмэлт зардлыг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

7.7. Ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр ажил гүйцэтгэх нарийвчилсан хуваарийг гарган мөрдүүлж болно.

7.8. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний дагуу ажлыг гүйцэтгэхдээ захиалагчийг явцын болон үе шатанд хяналтыг хэрэгжүүлэх нөхцөлөөр хангах ажлыг зохион байгуулна.

8. Ажлын доголдлыг арилгах, гомдлын шаардлага гаргах

8.1. Гүйцэтгэгч нь ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, эсхүл хууль тогтоомж, захиалагчийн өгсөн ажлын даалгавар, техникийн тодорхойлолт болон төрийн эрх бүхий хяналтын байгууллагын бичгээр өгсөн чиглэл, удирдамжийг зөрчиж гүйцэтгэсэн нь ажлын гүйцэтгэлийг хянах явцад болон энэ гэрээний гомдлын шаардлага гаргах хугацаанд илэрсэн бол уг зөрчлийг өөрийн хөрөнгөөр засаж доголдлыг арилгах, үүнээс үүссэн захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.

8.2. Гүйцэтгэгч ажлын үр дүнгийн доголдлын талаар санаатай нуун дарагдуулсан нь хожим илэрвэл тэрээр хариуцлагаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан шууд болон шууд бус хохирлыг бүрэн хариуцна.

8.3. Гүйцэтгэгч гэрээний нөхцөлийг зөрчсөн буюу гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол байвал захиалагч энэ тухай гомдлын шаардлагыг ажил хүлээн авснаас хойш гурван жилийн дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.

9. Мэдээлэл солилцох, мэдээллээр хангах

9.1. Талуудын албан ёсны хаяг:

9.1.1. Захиалагч: "Монголын төмөр зам" Төрийн өмчит хувьцаат компани

Улсын бүртгэлийн дугаар: 9012001025

Регистрийн дугаар: 5214203

Хаяг: Юнион бюлдинг, А блок, 7 давхар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 хороолол, Нарны зам-62, Улаанбаатар /14230/

Утас: 7000-6622, 7010-6655

Имэйл: info@mtz.mn

9.1.2. Гүйцэтгэгч: "Багануур Энерги" ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 2711002029

Регистрийн дугаар: 2009226

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: 185/19

Албан ёсны хаяг: Багануур дүүрэг, 1-р хороо, Нацагдоржийн гудамж, дэд станцын байр 0 тоот

Утасны дугаар 99023698

Гэрээний талууд үйл ажиллагаа эрхлэн явуулахад шаардлагатай мэдээллийг харилцан солилцож байна.

9.2. Мэдээллийг бичгээр болон факс, и-мэйл зэрэг цахим хэлбэрээр солилцоно.

9.3. Хойшлуулшгүй тохиолдолд талууд мэдээллээ амаар болон утсаар солилцож болох боловч ийнхүү солилцсон мэдээллээ баталгаажуулж 24 цагийн дотор нөгөө талд хүргүүлнэ.

9.4. Захиалагч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдээ баримт, судалгаа, зааварчилгааг ажил гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу боломжит хугацаанд гаргаж өгнө.

10. Ажлын гүйцэтгэлийг хүлээлцэх

10.1. Гэрээний хавсралт 1-т заасан техникийн тодорхойлолт, хавсралт 2-т заасан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замтай огтлолцож байгаа цэгүүдэд цахилгаан дамжуулах кабель шугамаар солих ажлын зургийн шаардлагыг хангасан, Гэрээний хавсралт 3-д заасан хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлыг Талууд харилцан гэрээний дүгнэлт, акт үйлдэн албан ёсоор хүлээлцэнэ.

11. Ажлын хөлс

11.1. Энэхүү гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх ажлын хөлс нь нийт 110,515,065 /нэг зуун арван сая таван зуун арван таван мянга жаран таван төгрөг /цаашид гэрээний үнэ гэх/ байна.

11.2. Ажлын хөлсөнд холбогдох татвар, хураамж /аж ахуйн нэгжийн орлогын, нэмэгдсэн өртгийн гэх мэт/, үнэ, хөлсөнд холбогдох татвар, хураамж, цалин хөлс, үндсэн ажлын зардал, бараа, материал, техник, тээвэр болон хяналтын зардал, тайланг эрх бүхий байгууллагаар батлуулах зардал, бусад холбогдох бүхийл зардал багтсан болно.

11.3. Ажил гүйцэтгэх хугацаанд ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн бараа, материал, түлшний үнэ өссөн, Засгийн газраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэн тогтоосон болон Захиалагчаас үл шалтгаалах байдлаар ажлын өртөг нэмэгдэхтэй холбогдсон эрсдэлийг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

12. Төлбөр тооцоо

12.1. Гэрээний эхний төлбөрийг ажлын гүйцэтгэл 50%-д хүрсэн тохиолдолд тухайн ажлын гүйцэтгэлийн дүнгээр нь тооцож, ажил хүлээлцсэн актыг үндэслэн олгоно.

12.2. Гэрээний үлдэгдэл 45%-ийн санхүүжилтийг ажлын үр дүнг актаар бүрэн хүлээлцсэний дараа ажлын 5 хоногийн дотор Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн олгоно.

12.3. Захиалагч тал төлбөрийг Гүйцэтгэгчийн Голомт банкин дахь 4601002284 тоот төгрөгийн дансанд гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлнэ.

12.4. Гэрээний үнийн 5 хувийг Гүйцэтгэгч нь ажлын чанарын баталгаа болгон үлдээх ба Захиалагчид хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 1 жилийн хугацаанд Захиалагчийн дансанд барьцаанд үлдээнэ.

13. Захиалагчийн эрх, үүрэг

13.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах;

13.2. Ажлын явцын тайланг Гүйцэтгэгчээс авах;

13.3. Гүйцэтгэгчийн гүйцэтгэж буй ажил, бусад дагалдах ажилд хяналт тавьж, цаг тухайд нь шалгах, шаардлага тавих, шаардлагатай гэж үзвэл ажлыг зогсоох,

13.4. Гүйцэтгэгч талын үйл ажиллагааны алдаа, зөрчлүүдийн улмаас үүссэн аливаа хохирлыг нөхөн төлүүлэх, ажил гүйцэтгэхэд гарсан бүх алдаа, зөрчлийг үнэ төлбөргүй дахин гүйцэтгүүлэхээр шаардлага тавих;

13.5. Шаардлагатай тохиолдолд ажлын гүйцэтгэлд хөндлөнгийн байгууллага, мэргэжилтнээр хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх эрхтэй.

13.6. Гэрээний хавсралт болох ажлын даалгавар, техникийн тодорхойлолт болон бусад бичиг баримтыг хууль тогтоомж, стандарт, эрх бүхий байгууллагаас баталсан журам, зааварт нийцүүлэн гаргах,

13.7. Захиалагч нь энэхүү гэрээнд заасны дагуу гэрээний үнийг Гүйцэтгэгчид хугацаанд нь төлөх;

13.8. Ажлыг хугацаанд нь гүйцэтгэхэд өөрсдийн зүгээс шаардлагатай туслалцааг Гүйцэтгэгч талд үзүүлэх;

13.9. Захиалагчийн зүгээс ажил хийж гүйцэтгэхтэй холбогдсон шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;

13.10. Энэхүү гэрээ, хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

14. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

14.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Захиалагчаас шаардах;

14.2. Гэрээний үнийг гэрээнд заасны дагуу хүлээн авах;

14.3. Захиалагч талаас гаргаж өгөх мэдээлэл, материалыг боломжит цаг хугацаанд нь шаардан авах;

14.4. Захиалагчтай ажлын тайлан, үр дүн, дүгнэлт дээр санал зөрөлдсөн тохиолдолд ажлын гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт хийлгэх;

14.5. Гэрээнд заасан ажлыг хууль тогтоомж, стандарт болон журам, аргачлал, Захиалагчаас өгсөн ажлын даалгаврын, техникийн тодорхойлолтын дагуу, баталгаажсан техник, технологийг ашиглан гүйцэтгэн, хүлээлгэн өгөх;

14.6. Захиалагчаас хяналт тавьж ажиллаж байгаа ажилтныг хоол, байраар хангах үүрэгтэй.

14.7. Ажлын гүйцэтгэлтэй холбогдсон алдаа, зөрчил, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэгдээгүй, чанарын доголдолтой үр дүн гарсан тохиолдолд Захиалагчид дахин үнэ төлбөргүйгээр засч өгөх, хохирлыг барагдуулах;

14.8. Гүйцэтгэгч нь ажлын үр дүнд бий болсон хөрөнгөд өгсөн чанарын баталгаат хугацаа 1 жил байна. Энэ хугацаанд ажил гүйцэтгэлийн болон ашигласан тоноглол, материалын чанараас шалтгаалан гарсан аливаа доголдлыг арилгах, Захиалагчид учирсан хохирлыг барагдуулах үүрэгтэй,

14.9. Ажлыг хэрэгжүүлэх ажлын арга, аргачлал болон гүйцэтгэх хугацааг үе шат тус

бүрээр хөтөлбөр боловсруулан Захиалагчид танилцуулах;

14.10. Энэхүү гэрээ, хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

15. Нууцлал

15.1. Гэрээ нь Талуудын нууцад хамаарах бөгөөд хууль болон гэрээнд зааснаас бусад тохиолдолд нөгөө Талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээний талаарх аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

15.2. Хуульд заасны дагуу байгууллагын нууцтай танилцах эрх бүхий төрийн байгууллага, түүний албан тушаалтан энэ зүйлд заасан мэдээлэлтэй танилцахаар хүсэлт гаргасан, эсхүл шаардсан тохиолдолд талууд уг мэдээллийг хуульд заасан журмын дагуу танилцуулах бөгөөд энэ талаар нөгөө талдаа урьдчилан мэдэгдэнэ.

15.3. Талуудын аль нэг нь энэ зүйлд заасан үүргээ зөрчсөний улмаас нөгөө талын бизнесийн нэр хүндэд хохирол учирсан, материаллаг хохирол учруулсан бол буруутай тал нь түүнийг бүрэн хариуцна.

16. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах

16.1. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

16.2. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд нөгөө Талдаа саналаа бичгээр хүргүүлэх бөгөөд тухайн саналд нэмэлт, өөрчлөлтийн үндэслэл, түүний төслийг тусгана.

16.3. Саналыг хүлээн авсан тал ажлын 14 хоногийн дотор хариу ирүүлэх үүрэгтэй бөгөөд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.

16.4. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

17. Гэрээний зөрчлийг арилгах, гэрээ цуцлах

17.1. Талууд гэрээний үүргийн зөрчлийг арилгах тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдэл хүргүүлэх бөгөөд мэдэгдлийг хүлээн авсан тал гэрээний зөрчлийг 7 хоногийн дотор арилгаж хариу мэдэгдэх үүрэг хүлээнэ.

17.2. Хэрэв зөрчил гаргагч Тал зөрчлийг 7 хоногийн дотор арилгах боломжгүй бол энэ тухай нөгөө Талдаа мэдэгдэх бөгөөд зөрчил арилгах хугацааг Талууд харилцан тохиролцож тогтооно.

17.3. Талууд гэрээг цуцлах саналтай байгаа бол уг саналаа нөгөө Талд бичгээр хүргүүлж, харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

17.4. Захиалагч нь дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

17.4.1. Гүйцэтгэгч энэ гэрээний дагуу ажил гүйцэтгэх хуваарь болон хугацааг 7 буюу түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн;

17.4.2. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэхдээ чанарын ноцтой доголдол гаргасан бөгөөд захиалагч ажлыг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй гэж үзсэн;

17.4.3. Гүйцэтгэгч нь ажлын доголдлыг боломжит хугацаанд арилгаагүй, эсхүл ийнхүү арилгахаас зайлсхийсэн;

17.4.4. Давагдашгүй хүчин зүйл 30 ба түүнээс олон хоног үргэлжилсэн бөгөөд ажлыг үргэлжлүүлэх шаардлагагүй гэж үзсэн;

17.4.5. Гүйцэтгэгчийнхуурамч баталгаа бусад бичиг баримтыг гаргаж өгсөн;

17.4.6. Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.

17.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

17.5.1. Захиалагч төлбөрөө шилжүүлэх хугацааг 7 буюу түүнээс дээш хоногоор

хэтрүүлсэн, цаашид боломжит хугацаанд шилжүүлэхгүй нь тодорхой болсон;

17.5.2. Захиалагч ажлын хамрах хүрээг өөрчилсөн нь энэхүү гэрээнд заасан ажлын хөлсийг нэмэгдүүлэх нөхцөл байдлыг бий болгосон бөгөөд захиалагч нэмэлт санхүүжилтийг гаргахаас үндэслэлгүйгээр татгалзсан;

17.5.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.

17.6. Энэ гэрээний 18.4, 18.5-д заасны дагуу нэг талын санаачилгаар Гэрээг цуцлах тохиолдолд Гэрээ цуцлах тухай мэдэгдлийг 10-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талд бичгээр хүргүүлнэ.

17.7. Гэрээг цуцалсан тохиолдолд ийнхүү цуцалснаас хойш ажлын 5 хоногийн дотор гэрээ цуцалсан өдрөөр тасалбар болгон Захиалагч гуравдагч ажил гүйцэтгэгчээр ажлыг гүйцэтгүүлэх эрхтэй. Хэрэв гүйцэтгэгчийн зохих ёсоор гүйцэтгээгүй ажлыг гуравдагч ажил гүйцэтгэгч үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжтой тохиолдолд тухайн ажилд ногдох гүйцэтгэгчийн зардлыг захиалагч төлөх тохиолдолд гуравдагч ажил гүйцэтгэгчтэй зөвшилцсөнийг үндэслэн тооцно.

17.8. Гэрээний 18.3 -т заасны дагуу аль нэг Талын санаачилгаар Гэрээг цуцалсан бол буруутайТал ийнхүү цуцалсантай холбоотой зардал болон нөгөө Талд учирсан хохирлыг нөхөн төлнө.

18. Хариуцлага

18.1. Гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.

18.2. Энэ гэрээний 18.4-д заасны дагуу гэрээг захиалагчийн санаачлагаар цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч гэрээний нийт үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний торгууль хүлээх бөгөөд захиалагчид учирсан хохирлыг бүрэн хариуцна.

18.3. Захиалагч нь энэ гэрээнд заасан үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх хэмжээний алданги хүлээнэ.

18.4. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээнд заасны дагуу нэг талын санаачилгаар гэрээг цуцалсан бол буруутай тал нөгөө талд учруулсан аливаа хохирол болон зардлыг нөхөн төлнө.

18.5. Хэрэв аль нэг тал нь үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь шаардах эрхээ хэрэгжүүлээгүй бол энэ нь эрхээсээ татгалзсан гэж тооцохгүй бөгөөд эрхээ хожим хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээ авахад саад болохгүй.

18.6. Аль нэг тал Гэрээгээр хүлээсэн үүргээ давагдашгүй хүчин зүйлийн улмаас зохих ёсоор биелүүлээгүй болох нь нотлогдвол үүрэг давагдашгүй хүчин зүйлийг арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно. Захиалагч төрийн эрх бүхий байгууллагаас хамааралтайгаар гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд саад учирсан тохиолдолд Захиалагчийн үүрэг тухайн нөхцөлийг арилах хүртэл хугацаагаар хойшилно.

19. Давагдашгүй хүчин зүйл

19.1. Дайн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, террорист халдлага, хүн малын гоц халдварт өвчний улмаас хөл хорио тогтоосон, байгалийн гамшигт үзэгдэл болох үер, хүчтэй шуурга болсон нь талууд үүрэг гүйцэтгэхэд саад учруулж байгаа, эсхүл гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үүргийн гүйцэтгэлийг тухайн нөхцөл байдал арилах хүртэлхугацаагаар хойшлуулна.

19.2. Давагдашгүй хүчин зүйл бий болсон эсэх талаар гэрээний талууд маргасан тохиолдолд Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас холбогдох лавлагааг авч маргааныг шийдвэрлэнэ.

19.3. Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас ажил гүйцэтгэх хугацаа болон

ажлыг сунгах, түүний төсөвт өртөгт нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү асуудлыг талууд харилцан зөвшилцөх замаар гэрээнд нэмэлт, хавсралтаар оруулж болно.

19.4. Эрх бүхий төрийн байгууллагын үйл ажиллагаанаас үүдэн ажил саатах, түр зогсох тохиолдолд талууд нэн даруй мэдэгдэж тухайн саатсан хоногоор гэрээт ажлыг хойшлуулах талаар талууд харилцан тохиролцоно.

20. Маргаан шийдвэрлэх

20.1. Талууд харилцан хүндэтгэлтэй, бизнесийн ёс зүйг чанд сахиж, гэрээтэй холбоотой аливаа маргаан гарахаас урьдчилан сэргийлж ажиллана.

20.2. Энэхүү гэрээг тайлбарлах болон түүний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

20.3. Талууд харилцан тохиролцоонд хүрэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

21. ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

“Монголын төмөр зам” ТӨХК
Инженер технологийн газрын дарга

Д.Нямлхагва



Гүйцэтгэгчийг төлөөлж:

“Багануур Энерги” ХХК-н
Гүйцэтгэх захирал

А.Буджав



Цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл

Захиалагчийг төлөөлж:

“Монголын төмөр зам” ТӨХК
Инженер технологийн газрын дарга

Д.Нямлхагва



Гүйцэтгэгчийг төлөөлж:

“БагануурЭнерги” ХХК-н

Гүйцэтгэх захирал

А.Буджав





БАГААНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСЭЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨЛЧИТ ХЭВЦЭГ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.ТАВИНБЭХ

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2019 оны 09-р сарын 25-ны өдөр

№ ДО 1925

Бөгжлөгч дүрэг

1. Техникийн нөхцөл
хүссэн хуулийн этгээд:

"Монголын төмөр зам" ТӨХК

2. Хэрэглэгчийн хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
13-р хороолол, Нарны зам-62
Утас: 700007722, 70100644

3. Хэрэглэгчийн байршил,
зэрэглэл:

Дорноговь аймэг
2-р зэрэглэл

4. Ажил үйлчилгээний
зорилго:

Тавантолгой-Эрүүбаян чиглэлийн төмөр замтай
огтлолцож байгаа цэгүүдэд цахилгаан дамжуулах
агаарын шугамуудыг кабель шугамээр солих.

5. Техникийн нөхцөл
олгох үндэслэл:

2019 оны 09 дугаар сарын 19-ны өдрийн №01/506
тоот албан ёсны

6. Өндөрлөх цэг:

Зорилг 4

*Тулгуур № 35-37 хооронд
үүлсн үндэслэл;*

6.1 15 кВ Хөвсгөл цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур №36-37 хооронд ергөн сайр, үерийн далантай, төмөр зам баганаг гүүрээр гаргах тул 15 кВ Хөвсгөл цахилгаан дамжуулах агаарын шугамыг өмнөр №35-с тулгуур №36-н хооронд нэг км газар шинээр агаарын шугам татаж тойруулж гаргах шаардлагатай. Төмөр замтай огтлолцсон цэгт 95 мм²-с багагүй хөндлөн огтлолын талбайтай, газарт булах зориулалттай 15 кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам татах. Төмөр замтай огтлолцсон тулгуурт 15 кВ-ын хуурай салгуур суурилуулна.

Зорилг 5

*№127; 128-2 өмнөр
тулгуур босоох
(өмнөрөөс урагш)*

6.2 15 кВ Хөвсгөл цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур №127, 128-н хоорондох 95 мм²-с багагүй хөндлөн огтлолын талбайтай, газарт булах зориулалттай 15 кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам татах. Цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур №127, 128-д 15 кВ-ын хуурай салгуур суурилуулна.

Эрх 6
*Шинэ тус тусуу бүрд-
үүлэх*
(мөрдөг сүлж)

6.3 22 кВ Магдах цахилгаан дамжуулах агаарын шугамын тусуур №84, 85-н хоорондох 95 мм²-с багагүй хөндлөн огтлолын талбайтай, газарт булах зориулалттай 22 кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам татах. Цахилгаан дамжуулах агаарын шугамын тусуур №84, 85-д 22 кВ-ын хуурай салгуур суурилуулна. Тусуур №84-г төмөр замын трассас 10 метр газар зөвж шилжүүлэх.

6.4 35/6/15 кВ Зүүнбаян дэд станц янгойк № 10 Орон сууц-1 6 кВ цахилгаан дамжуулах агаарын шугамын тусуур №11, 12-н хоорондох 95 мм²-с багагүй хөндлөн огтлолын талбайтай, газарт булах зориулалттай 6 кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам татах. Цахилгаан дамжуулах агаарын шугамын тусуур №11, 12-д 6 кВ-ын хуурай салгуур суурилуулна.

*Зорил №3 - тусуур №13-г
шилжүүлэх*

6.5 35/6/15 кВ Зүүнбаян дэд станц янгойк № 11 Орон сууц-2 6 кВ цахилгаан дамжуулах агаарын шугамын тусуур №13, 14-н хоорондох 95 мм²-с багагүй хөндлөн огтлолын талбайтай, газарт булах зориулалттай 6 кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам татах. Цахилгаан дамжуулах агаарын шугамын тусуур №13, 14-д 6 кВ-ын хуурай салгуур суурилуулна.

7. Тусгай заалтууд:

7.1 Эрсэн хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийн 2.2 дахь заалтын дагуу 1-20 кВ хүртэл цахилгаан дамжуулах агаарын шугамын зөвхөн утаснаас хоёр тийш хүн орсон сурдаггүй гэрлээр өнгөрөх нөхцөлд 10 метр байна гэсэн заалтыг баримтлах.

7.2 Шинээр татах цахилгаан дамжуулах агаар шугам, кабель шугамын трассын зургийг эрх бүрэн байгууллагаар хийлгэн, төлөвийн нөхцөл олгогчоор хянуулж, магадлан хяналтаар баталгаажуулна.

7.3 Шинээр татах цахилгаан дамжуулах агаар шугам, кабель шугамын трассын зургийг Дорноговь ЦТСС-ын инженер төлөвийн хэлтэстэй хамтран гаргана.

7.4 Шинээр татах цахилгаан дамжуулах агаар шугам, кабель шугамын трасс нь бусдын эзэмшлийн газар, мөхөөрлийн байгууламстай огтлолцож байгаа цэгүүдэд холбогдох эрх бүрэн байгууллагаас төлөвийн нөхцөл авна.

7.5 Шинээр хийгдэх цахилгаан угсралт, монтажийн ажилд хүчдлийн түвшингийн 20%-ийн холболтод ажиллах. Монгол орны цаг уурын нөхцөлд зохицсон, байгаль экологид сөрөг нөлөөлөлгүй, орчин үеийн шинэ тоног төхөөрөмж суурилуулна.

7.6 Шинээр татах цахилгаан дамжуулах агаар шугам, кабель шугамын угсралтын ажлыг "Эрчим хүчийг барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл"-тэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

7.7 Шинээр татах шугам тоногтолын барилга угсралтын ажлыг норм дүрмийн дагуу гүйцэтгэх, шаардлагатай хэмжээт туршилтыг БЗӨБЦТС ТӨХК-ийн Дорноговь ЦТСС-аар хийлгэх, холбогдох хүчин төгөлдөр акт, протоколыг бүрдүүлнэ.

8. Дор дурьдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

8.1 Техникийн нөхцөлд тусгагдсан эрчим хүчийг барилга угсралтын ажлыг гүйцэтгэсний дараа "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 4.22, 4.23 дугаар заалт, БЗӨБЦТС ТӨХК-ийн "Цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох объектыг ашиглалтанд хүлээн авах журам"-ын дагуу холбогдоно.

8.2 Хэрэглэгч нь Монгол улсын Эрчим хүчийг түгээх хуулийн 30.1.2, 30.1.3, 30.1.4, 30.1.7, 30.1.8 дугаар заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

8.3 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт асуутгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилж бөгөөд шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, үйлдвэрлэлийн бус барилга байгууламж барих, шугам сүлжээ өсгөлөгч, эзэмшлэгчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

8.4 Цахилгаан эрчим хүч хэрэглэгч нь Монгол Улсын Эрчим Хүчийг түгээх хууль болон цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

8.5 Хэрэглэгч нь "Цахилгаан байгууламжийн дүрэм"-ийн 4.2.72, 4.2.73, 4.2.74-р заалтуудыг баримталж угсралтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

8.6 Эрчим хүчийг сайдын 2013 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн 03 тоот тушаалын нэгдүгээр

хэсрэлтээр батлагдсан "Цэцэглээн эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох журам"-ын 6 дугь хэсэгт зэвсэг доорх заалтуудыг мөрдөж болгоно.

5.2 Техникийн нөхцлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно. Үүнд:

5.2.1 Техникийн нөхцөл авахын тулд техникийн хэрэглээний өгөгдлүүдээ зориуд буруу тодорхойлсон.

5.2.2 Холболт хийх цэгийн хүчин чадлаас хэтрүүлэн техникийн нөхцөл олгосон.

5.2.3 Техникийн нөхцлийн хүчтэй байх хугацаанд цэцэглээний сүлжээнд холбогдоогүй төвөгдөлд.

5.2.4 Хугацаа дууссан техникийн нөхцлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барилгыг хориглоно.

5.2.5 Техникийн нөхцлийн хүчтэй хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгуулах хүсэлтийг өргөмж хэсэгт гаргана. Хугацаа дууссан техникийн нөхцлийг хүчингүйд тооцно.

5.7 Техникийн нөхцөлд тусгагдсан заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд техникийн нөхцлийг хүчингүйд тооцно.

5.8 Техникийн нөхцлийн дагуу барилга угсралтын ажлыг хоёр жилийн хугацаанд хийж гүйцэтгэн түгээх сүлжээнд холбогдох бөгөөд энэ хугацаанд ажлыг хийж гүйцэтгээгүй тохиолдолд дахин шингээр техникийн нөхцөл өгнө.

Холбооны ТҮАХТ-эргүүн дэд засварал,

Ерөнхий менежер

ТҮАХБХ-ийн дарга

Боловсруулсан: ТНОЗИ менежер

Г.Шүрэнбулуун

Д.Мунхулга

А.Бямбажаргал

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замтай огтлолцож байгаа цэгүүдэд цахилгаан дамжуулах кабель шугамаар солих ажлын зураг

Захиалагчийг төлөөлж:

“Монголын төмөр зам” ТӨХК
Инженер технологийн газрын дарга

Д.Нямлхагва



Гүйцэтгэгчийг төлөөлж:

“БагануурЭнерги” ХХК-н
Гүйцэтгэх захирал

А.Буджав



Ажил гүйцэтгэх календарьчилсан төлөвлөгөө

Захиалагчийг төлөөлж:

“Монголын төмөр зам” ТӨХК
Инженер технологийн газрын дарга

Д.Нямлхагва



Гүйцэтгэгчийг төлөөлж:

“Багануур Энерги” ХХК-н
Гүйцэтгэх захирал

А.Буджав



Ажил Гүйцэтгэх Хугацааны Хуваарь

Захиалагч: "МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК

Ажлын нэр: 15-22кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр замтай огтлолцсон хэсгүүдийн агаарын шугамыг өөрчлөх ажил

Байрлал: Дорноговь аймгийн Хөвсгөл болон Мандах сум

Ажил гүйцэтгэх хугацаа: 2020 оны III/09 өдөр - 2020 оны IV/06 /Нийт - 30 хоног/

№	Ажлын нэр ба төрөл	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ	Төлөөлгөө / Гүйцэтгэл	2020 он			
					Ажил эхэлсэнээс хойш			
					Долоо хоног			
					I	II	III	IV
А. ХӨВСГӨЛ 15КВ АШ-ЫН ТУЛН 36-37 АШ-ЫГ ШИЛЖҮҮЛЭХ ЗӨРЛӨГ 4								
1	Шилжүүлэх тулгуур буулгах	1 тулгуур	1	төл				
				гүйц				
2	Одоо байгаа шугамаас утас хурааж авах	1 утас/км	2.16	төл				
				гүйц				
3	Одоо байгаа завсарын ТулН 35,37-ыг тулаас хийж эргэлтийн тулгуур УА15-3 болгох	2 тулгуур	2	төл				
				гүйц				
4	15 кв-ын цдаш-ын эргэлтийн тулаастай төмөр бетон тулгуур угсарч босгох УА15-3	2 тулгуур	2	төл				
				гүйц				
5	15 кв-ын АШ-ын завсарын төмөр бетон тулгуур шилжүүлэн угсарч босгох	3 тулгуур	1	төл				
				гүйц				
6	Тулгуурт төмөр бетон чагт угсрах	ш	5	төл				
				гүйц				
7	15 кв-ын хүчдэлтэй агаарын шугамын 50мм2 огтлолтой утасыг буцааж татах татах	км (3 утас)	0.293	төл				
				гүйц				
8	40*4 газардуулга сунгаж шуудуунд тавих	м	75	төл				
				гүйц				
9	22 мм голчтой бөөрөнхий төмрөөр хийсэн 2,0 метр урт газардуулгын гадас зоож шинтэй холбож гагнах.	ш	10	төл				
				гүйц				
10	Тулгуурын нүх эксковатороор ухаж овоолох	м3	6.87	төл				
				гүйц				
11	Газардуулгын шуудууг эксковатороор ухаж овоолох	м3	24	төл				
				гүйц				
12	Тулгуур газардуулгын нүхийг эргүүлж булах	м3	29.2	төл				
				гүйц				
Б. ХӨВСГӨЛ 15КВ АШ-ЫН ТУЛН 127-128 ӨӨРЧЛӨХ ЗӨРЛӨГ 5								
1	Шилжүүлэх тулгуур буулгах	1 тулгуур	2	төл				
				гүйц				
2	Одоо байгаа шугамаас утас хурааж авах	1 утас/км	0.9	төл				
				гүйц				
3	Одоо байгаа завсарын ТулН 127, 128-ыг тулаас хийж эргэлтийн тулгуур УА15-3 болгох	1 тулгуур	2	төл				
				гүйц				
4	15 кв-ын хүчдэлтэй агаарын шугамын 50мм2 огтлолтой утасыг буцааж татах	км (3 утас)	0.1	төл				
				гүйц				
5	Тулгуурын нүх 3-р зэргийн хөрсөнд гараар ухаж	м3	2.75	төл				
				гүйц				
6	Тулгуур нүхийг эргүүлж булах	м3	2.61	төл				
				гүйц				
В. МАНДАХ 22 КВ АШ-ЫН ТУЛН 84-ЫГ АНКЕРААР СОЛИХ АЖИЛ ЗӨРЛӨГ 6 А								
1	Анкер ба завсарын тулгуурын нүх эксковатороор 3-р зэргийн хөрсийг ухаж овоолох	м3	216	төл				
				гүйц				
2	Анкерын нүхэнд тэгшилгээ хийх	м2	25	төл				
				гүйц				
3	Хөрсийг хайргаар нягтруулж дэвсгэр үе хийх	м3	2.5	төл				
				гүйц				
4	Анкерын нүх бульдозероор хөрсийг түрж булах	м3	205	төл				
				гүйц				
5	Газардуулгын шуудууг эксковатороор 3-р зэргийн хөрсийг ухаж овоолох	м3	112	төл				
				гүйц				
6	Газардуулгын шуудууг эргүүлж гараар булах	м4	106	төл				
				гүйц				
7	Төмөр шон, хөндлөвчийг агаарын шугамын трассын дагуу ачиж буулгах	тонн	4	төл				
				гүйц				
8	Төмөр бетон суурь, хавтан, чагт зэрэг бүтээцүүдийг	м3	12	төл				
				гүйц				

	агаарын шугамын трассын дагуу ачиж буулгах	ш	8	гүйц				
9	Ф2-А маркийн төмөр бетон суурь суурилуулах	ш	8	төл				
				гүйц				
10	35 кв-ын 1 хэлхээт агаарын шугамын у35-1 маркийн төмөр тулгуур угсарч босгох.	ш	2	төл				
				гүйц				
11	35 кв-ын 1 хэлхээт агаарын шугамын у35-1+5 маркийн төмөр тулгуурын өндөрлөгөөг угсрах	тонн	6	төл				
				гүйц				
12	0,2 м3 хүртэл эзлэхүүнтэй ар-5, маркийн төмөр бетон чагт угсарч босгох	км (3 утас)	8	төл				
				гүйц				
13	35 кв-ын хүчдэлтэй нэг хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын АС 95мм2 огтлолтой утсыг татах.	м	0.17	төл				
				гүйц				
14	40*4 газардуулгын 40 м урттай урттай шинийг сунгаж шуудуунд тавих	ш	320	төл				
				гүйц				
15	Туршилт, тохируулгын ажил	ком		төл				
				гүйц				

Төлөвлөгөө гаргасан:

"Багануур-энерги" ХХК-ийн инженер

Г.Наранцэцэг



Хянасан:

"Багануур-энерги" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

А.Буджав



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 185/19

"Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай"
Монгол Улсын хуулийг үндэслэн

Улаанбаатар . аймаг/нийслэлийн Багануур сум/дүүргийн


"Багануур энерги" ХХК -д РД 2009226

03.2.4 заалтын дагуу

ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг

2019 оны 04-р сарын 23 өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай олгов

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД



Ц.ДАВААСҮРЭН

2019 оны 04-р сарын 23 өдөр

Улаанбаатар хот

00746

Ажил үйлчилгээний төрөл

03.2.4

0.4-110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар, түүний туршилт-тохируулга, дагалдах ажил үйлчилгээ

—oOo—

Нэмэлт өөрчлөлт:

Сайд /
 оны -р сарын өдөр

СУНГАЛТ:

. оны -р сарын өдрөөс эхлэн жилийн хугацаатай сунгав

Сайд /
 оны -р сарын өдөр